

**МОНГОЛ ХЭЛНИЙ ЗАРИМ ХЭЛЦИЙН УТГЫГ МОНГОЛ БИШ ХЭЛТЭН
ОЙЛГОХОД ТУЛГАРДАГ ГОЛ БЭРХШЭЭЛ**

Б. Баяртуул *

Түлхүүр үг: хэлц нэгж, ёс заншил, соёл, үндэстний сэтгэлгээ, хоёрдогч хэл, утга

Хэлний аливаа үзэгдэл баримтанд “цэвэр” хэл шинжлэлийн үзэл онол, арга зүйг үндэслэгээ болгодог нь хэл шинжээчдийн хэдэн үеийнхний гол арга барил байсаар иржээ. Гэвч хэл ямар нэгэн заяамал зүйл биш, харин хүний өөрийнх нь практик үйл ажиллагаа, ухамсар, сэтгэхүй, танин мэдэхүйн үйл ажиллагааны үр дүн гэдэг тодорхой болсоор байгаа бөгөөд аливаа хүн эх хэлээ эзэмших, өөр хэл сурах зэрэгт хамгийн чухал асуудал бол үндэстний сэтгэлгээ буюу хэл, соёл хоорондын харилцан холбоо, хэлний нийгэм болон оюун санаа, соёлын агуулгатай харилцаа холбоотой байдал, түүнчлэн нийгэм дэх хүн ба соёл хоорондын харилцан холбоо зэрэг юм. Үндэстний сэтгэлгээ, түүний онцлогийн хамгийн тод илрэл болсон хэлцийн утгыг ойлгож ухах явдал хэл сурч, судлахын гол зангилаа, хэл шинжээч, соёл судлаач нарын анхаарлыг татсан асуудал болжээ.

Хэлц гэдэг зөвхөн хэлний нэгж төдий бус, хүн хүрээлэн буй орчинтой харилцан хамааралтай байдаг онцлогийг тодорхой тусгасан ертөнцийн зураглалын талаархи ойлголт юм. Эрдэмтэд ертөнцийн зураглал гэдгийг “соёл бүрт байдаг ертөнцийн загвар цаг хугацаа, орон зай, хэмжигдэхүүн, хувь тавилан, тоо, мэдрэмтгий болон хэт мэдрэмтгий харилцаа, хэсгээс бүхэлд харилцах гэсэн харилцан холбоо бүхий нийтлэг ойлголтын нэгдлээс бүрддэг” (Гуревич. 2004. х-38)¹ хэмээн тодорхойлдог байна. Өөрөөр хэлбэл, ертөнцийн зураглал хэл, сэтгэхүй хоёр нягт холбоотойн нэг тод жишээ бөгөөд нийгмийн амьтан болох хүний оюуны идэвхтэй үйл байдлыг дуу авианы

* МУИС-ийн МХСС-ийн Монгол хэлний тэнхим

¹⁾ П.С.Гуревич, *Соёл судлал*, 1-р дэвтэр, Улаанбаатар, 2004.

тусламжтайгаар илэрхийлсний нэгэн онцгой үр дүн бол хэлц юм. Үндэстэн бүр ертөнцийг өөр өөрийнхөөрөө хүлээн авч байдаг нь тухайн үндэстний амьдралын хэв маяг, сэтгэлгээтэй холбоотой. Жишээлбэл: Үндэстний хоол хүнсний голлох бүтээгдхүүн тогтвортой нийлэмж тэр дундаа хэлцэд илрэлээ олсон байдаг. Монголын ард түмний хувьд цагаан болон улаан идээ голлох хүнс болж ирсэн, болж байгаа нь эрхэлж буй аж ахуй, амьдрал байдалтай салшгүй холбоотой байх жишээтэй. Нийгмийн тогтолцоо болон соёл иргэншил бүр дэлхий ертөнцийг өөр өөрийн онцгой аргаар ойлгон ухаарч тодорхойлж байдаг бөгөөд түүний гэрч баримт болсон хэлний үзэгдэл, ялангуяа хэлц бол тухайн үндэстний уламжлалт аж ахуй, эртнээс нутаглан суурьшсан газар орны байгаль, цаг уурын онцлог хийгээд юуг эрхэмлэн дээдэлж, юуг цээрлэн жигшдэг зэрэг зан заншил, шашин шүтлэгийн уламжлал, эдгээрийн тухай хэвшсэн ойлголт, ухаарал, мэдлэг, боловсролын бүхий л байдал туссан байдгаараа үндэстний сэтгэлгээ, соёлынх нь өвөрмөц байдлыг тандан судлах чухал баримт болдог байна² гэж доктор Ж.Баянсан “Соёл, хэл, сэтгэлгээ” номдоо бичжээ.

Монгол биш хэлтэн монгол хэлийг тодорхой төвшинд төгс эзэмших, түүний дотроос хэлцийн утгыг гүнзгий ухамсарлан танихад доорхи бэрхшээл учирдаг гэж үзэж болохоор байна.

1. Хэлцийн хэлбэрийн талын онцлог буюу юугаар хэрхэн илэрч буйн бэрхшээл. Энэ бэрхшээлийг даван туулахын тулд доорхи зүйлийг мэдэх хэрэгтэй. Үүнд,

- Хэлзүйн утга хэлний нэгжээр илрэхийг хэлзүйн хэлбэр гэдэг. Хэлзүйн хэлбэр тусгай аргаар илрэх бөгөөд монгол хэлний аливаа хэлц найрах, хамжих хоёр төрөл бүхий задлаг аргад тулгуурлан бүтдэг, найрах аргад: -ын, -ийн, -н; -д, -т, аа⁴; -ыг, -ийг, -г; -аас⁴; -аар⁴; -тай³; -руу² (луу²); -аад⁴; мэт, шиг, адил, лугаа адил, лүгээ адил, лугаа ижил, лүгээ ижил гэх мэт нэрийн тийн ялгалын нөхцөл болон түүнийг орлох үгэлбэр; -хлаар⁴, -хаар⁴, -бал⁴, -вал⁴; -мааж⁴, -саар⁴, -магц⁴, -тал⁴, -ж,ч, -н, -нгаа⁴, -вч, -лгүй, -хнаа⁴, -нгуут², -руун² гэх мэт үйлийн тийн ялгалын нөхцөл, түүнийг орлох үгэлбэр цөм холбох хэрэглүүр, хамжих аргад нэр үйлийн үндэс холбох хэрэглүүр болдог гэдгийг мэдэх;

- Хэлцийг цөм буюу гол үгээр нь: орчлонгийн улаан тоос, ингэн нүд, хөгшин хонины насгүй, хулгана залгисан могой шиг, яргуй хөөсөн ямаа шиг, харцганд хөөгдсөн болжмор шиг гэх мэт нэр үг цөмтэй; навчинд бараалхах, батганын хошуу багтахгүй, шороо үмхэх, тэнгэрт тултал магтах гэх мэт үйл цөмтэй болдгийг мэдэх

- Хэлцийг бүрэлдүүлэгчийн тоогоор: ингэн нүд, навчинд бараалхах, шороо үмхэх гэх мэт харьцангуй бүтэцтэй; орчлонгийн улаан тоос, хөгшин хонины ясгүй, харцганд

²) Ж.Баянсан, Соёл, хэл, үндэсний сэтгэлгээ, Улаанбаатар, 2002, 43-р хуудас.

хөөгдсөн болжмор шиг, батганын хушуу багтахгүй гэх мэт дэлгэрэнгүй бүтэцтэй хэлц гэж ангилдгийг мэдэх шаардлагатай байдаг.

2. Агуулгын талын бэрхшээл. Энэ бэрхшээлийг даван туулахын тулд доорхи зүйлийг мэдэх хэрэгтэй. Үүнд,

- Хэлц: далд утгатай, адилтгалаар бүтсэн, санааг оновчтой, уран яруу, товч тодорхой илэрхийлдэг, түүхэн шинжтэй, гишүүн нь утгын хувьд салшгүй нягт холбоотой байдгийг мэдэх

- Ертөнцийн хэлний зураглалын онолын загварчлалыг мэдэх шаардлагатай. Үүнд, хүн төрөлхтөний нийтлэг ертөнцийн зураглал, ард түмний үндэсний зураглал гэсэн хоёр зүйл зураглал байдаг гэж үздэг бөгөөд сүүлийн жилүүдэд ертөнцийн үндэстний зураглалыг хэл, соёл судлаач нар болон заах арга зүйчид хэл соёл судлалын чухал чиглэл болгон судалж байна. Аливаа хэл зөвхөн авиа зүй, хэлзүй, үгийн сангаараа төдийгүй мөн ертөнцийг үзэх үндэстний соёлын өвөрмөц байдлаар ялгардаг. Утга учрын үнэн бодитой энэхүү гишүүнчлэл ертөнцийг үзэх үндэсний үзлийг бүрдүүлнэ.(Телия, 1983. х-84).³ Тиймээс монгол хэлний хэлцийг судлах нь хэл судлал төдийгүй хэлцээр дамжуулан үндэстний сэтгэлгээ, түүний онцлог ба нийтлэг талыг тодруулахад зайлшгүй хүргэдэг бөгөөд монгол биш хэлтний хувьд монгол хэлний хэлцийн онцлог талыг тодруулах, ойлгож эзэмшихэд ихээхэн бэрхшээл учирдаг байна.

- Аливаа хэлний хэлц судлалын эн тэргүүний асуудал бол тухайн хэлцийн уг сурвалж, учир холбогдлыг тодруулах буюу үүсгэл санааг олж тогтоох явдал юм. Өөрөөр хэлбэл, хэлц бүрийн түүх, гарлыг мэдэх шаардлагатай. Энэ нь дээр цухас дурдсанчлан, тухайн хэлээр хэлэлцэгч ард түмний аж амьдрал, эрхэлдэг аж ахуй, газар нутгийн байршил, зан суртахуун, ертөнцийг үзэх үзэл зэрэгт тулгуурласан тухайн үндэстэн угсаатны сэтгэлгээтэй салшгүй холбоотой байдаг.

Монгол хэлний хэлцийн тухайд ч ялгаагүй, хэлц бүр монгол хүний аж амьдралын үндэс болсон нүүдлийн мал аж ахуй, өргөн уудам нутаг орон, онгон дагшин байгаль дэлхийтэй нь нягт шүтэлцээтэй үүссэн байдаг ажээ. Жишээ нь: Амыг нь тэмээ тийрэх (идэж уух заяагүй болох), морийг нь эмээллэх (даамжруулах), яргүй хөөсөн ямаа шиг (тогтворгүй), хэвтээ хонь үргээхгүй (гэмгүй, номхон), дөргүй бух шиг (зөрүүд), бүүрэгнээсээ зуурах (бээвийгээд хөдөлж ядах)⁴ гэх мэтээр Г.Акимийн “Монгол хэлний өвөрмөц хэлцийн товч тайлбар толь”-д тайлбарлажээ.

- Монгол хэлний хэлцийн утгын ангиллыг сайн мэдэх хэрэгтэй. Монгол хэлний

³) В.Н.Телия, *Что такое фразеология*, Москва, 1966.

⁴) Г.Аким, *Монгол өвөрмөц хэлцийн товч тайлбар толь*, Улаанбаатар, 1982.

хэлцийг эрдэмтэд ерөнхий утгаар нь доорхи байдлаар ангилдаг байна. Үүнд,

1. *Сүнс халих, тэнгэр тэтгэх, тэнгэр хаях, төрөл арилжих, шар шувтлах* гэх мэт шүтээн шүтлэгтэй холбоотой үүссэн хэлц.

2. *Толгой хаялах, бөхгүй тэмээ, бөхгүй байж туг ширээ, ямаан омогтой, морийг нь унуулах, хонь шиг, үхэр шиг, өттэй тэмээ шиг* гэх мэт мал сүрэгтэй холбоотой үүссэн хэлц.

3. *Аяга ёроолдох, тогооны бариул, галын хайч, буруу шилэсэн сүх шиг, өрөөсөн гутал, өрөөсөн дугуй* гэх мэт эдлэл хэрэглэлтэй холбоотой үүссэн хэлц.

4. *Хоёр зээрд, хоёр нүүр, долоон гол, таван салаа хүртээх, таван хялгас* гэх мэт тоо тооллоготой холбоотой үүсэн хэлц.

5. *Цагаан санаа, хар хэл, хар санаа, улаан галзуу, хүрэн бөөртэй* гэх мэт өнгөний бэлгэдэлтэй холбоотой үүссэн хэлц.

6. *Алтан ам, алтан гар, алтан босго, мөнгөн толгой, сувдан дусал, зэс нь цухуйх* гэх мэт эрдэнэстэй холбоотой үүссэн хэлц.

7. *Бул чулуу, гал ус хоёр, даваан дээрээ гарах, өдөр шөнө шиг, хуй салхи шиг* гэх мэт байгалийн юм үзэгдэлтэй холбоотой үүссэн хэлц.

8. *Будааны сав, таргийн сав, хоол ороох, хоол буудах* гэх мэт хоол хүнстэй холбоотой үүссэн хэлц гэх буюу товчоолбол,

- Амьтан (ингэн нүд, хөгшин хонины ясгүй, хулгана залгисан могой шиг)
- Ургамал (яргуй хөөсөн ямаа шиг,)
- Адгуусны бүтээсэн зүйл (харцаганд хөөгдсөн болжмор шиг, батганы хошуу багтахгүй)
- Гараг ертөнц (орчлонгийн улаан тоос, шороо үмхэх, тэнгэрт тултал магтах)
- Сэтгэхүй (сэтгэл бэлчих, сэтгэл өвдөх, ухаанд нт ухна үхэх)
- Мэдрэхүй (уйлах ихдэх, нойрын тулам)
- Зөн билиг (зүүд зэрэглээ шиг, зүүдээ ярих гээд хулгайгаа ярих)
- Хий үзэгдэл (сүнс нь халих, ад шүглэх) гэж зүйлчилэн хуваасан байна.⁵

Аливаа ард түмний үндэсний хэл уг ард түмний олон зууны турш хуримтлуулсан амьдралын туршлага, соёлын тусгал, энэхүү соёлын баялаг сан гэж үзвэл хэлц нь энэ соёлын өвөрмөц нэгэн тусгал болно. Ард түмний амьдралын хэв маяг загварчлагдан хэлэндээ шингэдгийн нэг тод жишээ бол хэлц бөгөөд хэлцийг бүрэн ойлгохын тулд түүний утгын бүрэлдүүлбэрт байгаа соёлын бүрэлдүүлбэрийг тооцохгүй байхын аргагүй. Учир нь хэлц бол ард түмний хэлээр илэрхийлсэн, загварчилсан, хураангуйлсан соёл юм. Аливаа хэлц уг ард түмний ертөнцийг үзэх үзэл хэлэндээ шингэсний гэрч

⁵⁾ М.Базаррагчаа, *Монгол хэл VIII*, Улаанбаатар, 1999.

баримт бөгөөд хэлний зураглалын нэг төрөл зүйл болно. Тиймээс монгол биш хэлтэн төдийгүй монгол хэлтэн ч монгол хэлний хэлцийн утгыг сайтар ухаж мэдэхийн тулд Монголын түүх, соёл, ахуй амьдралтай нягт уялдаа холбоотой авч үзэх нь чухал байна.

Ер нь аливаа хэлний хэлц нэгжийг хэрхэн эзэмшсэнээс тэр хүний хэл, соёлын мэдлэгийн хэмжээ харагддаг.

Монгол биш хэлтэн монгол хэлний зарим хэлц нэгжийг ойлгоход бэрхшээл учирдаг шалтгааныг товчхон тодруулбал, хэлц нэгж монголчуудын олон зуун жилийн түүх, эрт дээр үеэс бүтээсэн эдийн болон оюуны соёл, монгол хүний ертөнцийг үзэх үзэл, сэтгэлгээ, аж төрөх ёс, зан үйлийн ойлголтыг тусгасан байдагт оршино. Зарим хэлц нэгжийг монгол биш хэлтэн байтугай унаган монгол хэлтэн ч үл ойлгох тохиолдол байдаг.

Монгол биш хэлтэн монгол хэлний хэлц нэгжийг ойлгоход зарим бэрхшээл тулгардаг учрыг дүгнэн хэлбэл:

1. Тухайн хэлэнд байдаггүй үг, хэллэг хэлц нэгжид элбэг тохиолддог.
2. Тухайн хэлтэнд байдаггүй соёл, ёс заншлыг тусгасан байдаг.
3. Монгол хүний ертөнцийг үзэх үзэл, сэтгэлгээ, үнэлэмж монгол биш хэлтнийхээс өөр зэрэг болно.

Түүнчлэн, хэлц нэгжийн утгыг монгол биш хэлтэн энгийн тайлбараас шууд ойлгох боломжтой буюу гүн бус утгат; энгийн тайлбараас шууд ойлгох боломжгүй буюу гүн утгат гэж ангилж болохоор байна. Жишээлбэл:

Гүн бус утгат: “Ухаан суух”, “будaa идэх”, “үнэ хадах”, “дээлийн гол”, “зүү орох зайгүй”, “замаа алдах”, “олон гартай”, “өдрийн од шиг”, “хаврын тэнгэр шиг” гэх мэт.

Гүн бус утгатай хэлцийг энгийн тайлбараас ойлгох боломжтойгоос гадна тухайн гадаад хэлний ойролцоо утгатай хэлцээр дүйлгэн орчуулж болно.

Гүн утгат: “Ухаанд нь ухна ишиг үхэх”, “уургын морь шиг”, “тосонд умбаж, торгонд хөлбөрөх”, “бухын доодохыг харж үнэг турж үхэх”, “сүүнд халсан хүн тараг үлээнэ” “эсгий хийх газар хүүхэд нохой хоёр хэрэггүй” гэх мэт олон жишээ хэлж болохоор байна.

Гүн утгат хэлц нэгжийн утгыг энгийн тайлбараас ойлгох амаргүй. Жишээлбэл, “Эсгий хийх газар хүүхэд нохой хоёр хэрэггүй” гэдэг хэлцийг англи хэлээр “Bull in a china shop”⁶ гэж хэлдэг байна. Үгчилбэл, шаазан эдлэлийн дэлгүүрт бух байх гэсэн шиг утгатай бөгөөд шаазан эдлэлийн дэлгүүрт бух байх нь ямар ч хэрэггүй гэсэн санаа нь монгол хэлний эсгий хийх газар хүүхэд нохой хоёр хэрэггүй гэдэгтэй дүйж байна. Нээрээ л шаазан эдлэлийн дэлгүүрт бух байвал мөргөж хагалах, эвдэж сүйтгэхээс өөр

⁶) Бат-Ирээдүй Ж, *Монгол-Англи хэлц үг, хэвшмэл хэллэгийн дүймэн*, Улаанбаатар, 2007.

ямар ч тус үзүүлэхгүй.

Мөн үүнийг япон хэлээр 牛の角を蜂が刺す(ushi no tsuno o hachi ga sasu)⁷ гэж дүйлгэж болох бөгөөд үгчилбэл үхрийн эврийг зөгий хатгах гэсэн утгатай юм. Нээрээ ч үхрийн эврийг зөгий хатгаад ямар ч нэмэргүй, үр дүнгүй, хэрэггүй гэсэн шиг утгатай байна гэж бид ойлгож чадах боловч гадаад хүн “Эсгий хийх газар хүүхэд нохой хоёр хэрэггүй” гэдгийг шууд ойлгож чадахгүй. Харин ч хүүхэд эсгий хийхэд аав ээж, ах эгчдээ тус болоод байж болно шүү дээ гэсэн санаа төрнө. Энэ хэвшмэл хэллэгийг ойлгохын тулд эхлээд эсгий яаж хийдэг зан үйлийг мэдэх хэрэгтэй. Энэ үйлийг бусдын тайлбар яриа, гэрэл зураг, уран зураг, кино зэргээс үзэж болохоос гадна хөдөө явж бодитоор үзвэл илүү сайн ойлгох болно. Энэ их ажлын хажуугаар хүүхэд нохой нааш цааш гүйж тоглоод ноос савж байгаа саваанд оногдох аюултай. Мөн монголчууд нохойны үсийг бузар гэж үздэг бөгөөд нохойны үс эсгий хийж буй ноостой холилдвол эсгий задарч муу болдог⁸ гэдгийг мэдвэл илүү сайн ойлгож болно.

Дүгнэж хэлбэл, үгийн сангийн салбар дотроос монгол биш хэлтний сурч эзэмшихэд нэлээд бэрхшээлтэй нарийн, түвэгтэй салбар нь хэлц нэгжийн судлал юм. Тиймээс монгол биш хэлтэн монгол хэлний хэлц нэгжийг сайтар ойлгож мэдэхийн тулд Монголын нийгмийн амьдралын бүхий л хүрээнд монгол хэлийг харилцааны хэрэглүүр болгон хэрэглэх чадвар дадалтай болох, цаашид бие даан мэдлэг боловсролоо нэмэгдүүлэх, улмаар гүнзгийрүүлэн судалж, таних зайлшгүй шаардлага байдгийг тэмдэглэе.

НОМ ЗҮЙ

- А.Аким (1982), *Монгол өвөрмөц хэлцийн товч тайлбар толь*, Улаанбаатар.
Д.Бадамдорж (2001), *Монгол хэлний утга судлал*, Улаанбаатар.
М.Базаррагчаа (1999), *Монгол хэл* YIII, Улаанбаатар.
Ж.Бат-Ирээдүй (2007), *Монгол-Англи хэлц үг, хэвшмэл хэллэгийн дүймэн*, Улаанбаатар.
Ж.Баянсан (2002), *Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ*, Улаанбаатар.
В. Bayartuul (2011/4), *Teaching Mongolian vocabulary to MSL students*, Боловсрол Судлал, Улаанбаатар.
П.С. Гуревич (2004), *Соёл судлал*, 1-р дэвтэр. Улаанбаатар.
Чой. Лувсанжав (1970), *Орос-монгол өвөрмөц хэллэгийн толь*, Улаанбаатар.

⁷⁾ ことわざ辞典、旺文社 1996

⁸⁾ С.Дулам, *Монгол судлал – шинэ чиг хандлага*, ОУ-ны хурал, 2012.

Х.Лувсанбалдан. Ц.Шагдарсүрэн (1971), *Монголчуудын үсэг бичиг, үг хэллэгийн түүх гарлаас*, Улаанбаатар.

В.Н. Телия (1966), *Что такое фразеология*, Москва.

ことわざ辞典、旺文社 1996.

SUMMARY

The acquisition of proverbs, phrases and idioms of any languages can describe the level of his/her linguistic and cultural knowledge.

Why is it complicated to understand some Mongolian idioms for non-Mongolian speakers? Because Mongolian idioms focus long history, traditional culture and custom, as well as ideology and lifestyle of Mongolian people.

According to our research, we have found some problems on it, as the following:

1. There are numbers of words or phrases in Mongolian idioms which are not in any other languages.
2. Mongolian idioms show the culture or custom which are not focused in other languages.
3. Ideology, evaluation and thinking of Mongolian people are different from other nationalities.

Therewith, we are classifying the idioms into two categories:

1. Idioms of which meaning is not deep. It means that Mongolian idioms can be understood easily from simple explanation.

For example: *Ухаан суух, будаа идэх, үнэ хадах, дээлийн гол* etc.

2. Idioms of which meaning is deep. It means that Mongolian idioms cannot be understood easily from simple explanation.

For example: *Ухаанд нь ухна ишиг үхэх, уургын морь шиг, тосонд умбаж, торгонд хөлбөрөх, бухын доодохыг харж үнэг турж үхэх* etc.

To sum up, the idioms are the most complicated part in lexicology. Therefore, non-Mongolian speakers have to get the skills of using Mongolian language in each level of communication.

Eventually, the most important goal of Mongolists is to be always initiative for doing research work on that.